

70 41

**МОНГОЛЫН АРДЧИЛСАН СЭРГЭНМАНДЛЫН НАМ,
МОНГОЛ АРДЫН НАМЫН "АРДЧИЛСАН ТӨР" ЭВСЭЛ**



**1996 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛЬД
ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

1996. 04. 24

**МОНГОЛЫН АРДЧИЛСАН СЭРГЭНМАНДЛЫН НАМ,
МОНГОЛ АРДЫН НАМЫН "АРДЧИЛСАН ТӨР" ЭВСЛИЙН
1996 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛД ОРОЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Монгол улс оршихын тулд,

Монгол орон хөгжин цэцэглэхийн тулд,

Монгол хүн эрх чөлөөтэй, энх амгалан, аз жаргалтай аж төрөхийн тулд 1996-2000 оны хооронд Монгол төр дараах хөтөлбөр хэрэгжүүлэх ёстой гэж үзэж "Ардчилсан төр" эвсэл Улсын Их Хурлын сонгуульд оролцож байна. Үндэ :

**I. Төрийн байгуулал, ардчилал,
шударга ёс**

Төр нь ард түмнийхээ итгэл хүлээж, иргэнээ баталгатай хамгаалж, улс нийгмээ ардчилсан зарчмаар зөхиөн байгуулж, шударга ёс төгтоох чадвартай, түүнд нийцсэн зохион байгуулалттай байвал улс орон энх амгалан болж хөгжин цэцэглэнэ.

Үүний тулд:

1. Төрийн байгуулалтыг төгөлдөржүүлэх шаардлагатай:

1.1. Бүх ард түмнээр сонгогддог Ерөнхийлөгчийн засаглалтай төр хэрэгтэй. Одоогийн 3 толгойтой төр нийгмээ жолоодох чадвар мөхөс байгааг гэтлэн давах ёстой.

1.2. Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага нь Бүх шатандаа ард түмнээр сонгогддог засаг дарга нар болон хууль тогтоох хурал, засгийн газрын гишүүд, шүүх засаглал, үндэний чөлөөт мэдээллийн хэрэгслийн төлөөлөгчдөөс бүрддэг Монгол Улсын Их Хуралдай байх болно.

1.3. Хууль тогтоох эрхийг улс төрийн хүчнүүд ард түмнээ хүлээсэн итгэлээр төлөөлөгдсөн 30-40 хүнтэй хууль тогтоох хурал эдэлнэ.

1.4. Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн

засаг даргын тамгын газруудыг улс төрийн хүчнүүдийн ард түмнээсээ сонгуулиар хүлээсэн итгэлийн харьцаагаар зөвшлийн зарчмаар бүрдүүлж байгуулна. Төрийн аль ч шатанд нэг улс төрийн хүчний ноёрхол тогтоохгүй.

1.5. Шүүх засаглалын нэгдмэл тогтолцоо бүрдүүлж, түүнийг Засгийн газар, хууль тогтоох хурлаас бүх талаар хараат бус нөхцөлд ажиглуулж, хуулийг дээдэлсэн шударга бөгөөд няцалтгүй цэрлэлтэй ёсыг сэргээнэ.

1.6. Монгол төрийн улс үндэстнийхээ язгуур эрх ашгийг дээдэлсэн бодлогын улсэмжлэлийг хангана.

1.7. Төрийн албан хаагчдад мэдлэг боловсролоо төрийн зардлаар байнга дээшлүүлэх, мэдээлэл олж авах хамгийн таатай нөхцөл бүрдүүлнэ. Төрийн ажилтан бэлтгэх эрдмийн их сургууль байгуулна.

1.8. Олон нийтийн байгууллагуудыг дэмжиж, нийгмийн нийтлэг зорилгуудыг шийдвэрлэхэд тэдний нөлөөг дээшлүүлэх бодлого баримтална.

1.9. Монгол улсын нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийг ард түмний сангалын үндсэн дээр улс үндэстнийхээ язгуур эрх ашигт нийцүүлэн боловсронгуй болгоно.

2. Ардчилал, шударга ёсны зарчмуудыг бэхжүүлж, хамгаална:

2.1. Монгол улс дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар хүлээсэн үүргийг хөсөрдүүлж буй бүх илрэлүүдийг таслан арилгана. Иргэдийн эрх чөлөөнд хууль бусаар халдах, цэргийн алба хааж буй, ял эдэлж буй хүмүүсийн төрөлхийн эрхийг зөрчих, улс төрийн мөрдөглт мөшгөлт сэргэх зэрэг гажуудлыг эрс шийдвэртэй арилгана.

2.2. Иргэдийн хувийн өмчийн эрхийг хохироож, төр засгийн зохицуулалт, татвар санхүүгийн бодлогоор хувийн өмчийн аж ахуйнүүдыг хавчиж байгаа болон өмч хувьчлалын явцад эрхийн бичгээр авсан хувьцааг ханш унагаж өмчийг завшсан гажуудлыг арилгаж залруулна.

2.3. Олон түмэн улс нийгмийнхээ амьдрал, төр засгийн үйл ажиллагааны талаар үнэн зөв, бүрэн дүүрэн мэдээлэлтэй байх эрхийг баталгаажуулж, радио, телевизийн өргөн нэвтрүүлэг, төрийн төв хэвлэлүүдийг Үндэсний чөлөөт

мэдээллийн тогтолцоонд шилжүүлнэ. Үндэсний чөлөөт мэдээллийн тогтолцоог дэмжиж хөгжүүлэхэд Улсын төсвийн 3%-иас доошгүйг зарцуулах зарчмыг тухайн засгийн газрын эрх мэдлээ үл хамгаруулан хуулиар баталгаажуулж, одоогийн санхүүжилтийг 1,5-2 дахин нэмэгдүүлнэ. Улсын төсвийн зарцуулалт, гадардын зээл тусламжийн хуваарилалт, ор төлбөрийн барагдуулалт, төр засгийн үйл ажиллагааны тухай мэдээллийг нийтэд ил болгоно.

2.4. Төр засгийн байгууллагад ажиллагсдыг улс төрийн албан тушаалтны "баг"-аар бүрдүүлж, үзлээр гадуурхах хэлбэрээр гарч буй гажуудлыг арилгаж, төрийн ажлын мэдлэг, зүтгэл, ажиллах чадварыг гол шалгуур болгож, төрийн албыг төвшитгөнө.

2.5. Улс нийгмийн нийтлэг эрх ашигт хохирол учруулсан Улсын банкны арбитражийн гүйлгээний алдагдал буюу "Алт", дилерийн хэрэг", Улсын төсвийн хөрөнгийг хувийн аж ахуйнуудаар дамжуулан завшсан асуудлууд, улс орны аюулгүй байдлад хохирол учруулж гадардын этгээдүүдтэй гэрээ хэлэлцээр байгуулсан хэргүүдийн үнэн мөнийг олж, зохиц хуулийн дагуу шийдвэрлүүлэн олон түмэнд бүрэн хэмжээгээр мэдээлж шударга ёсыг сэргээнэ.

2.6. Төрийн байгууллагуудад ажиллагсад, түүний дотор өндөр албан тушаалтнууд хээл хэхууль авч, албан тушаалаа хувьдас ашигласан тухай асуудлуудыг нягтлан шалгуулж, хууль болон ёс зүйн үнэн бодитой үнэлэлт өгч, нийтэд үнэнээр нь мэдээлж цаашид төрийг хээл хэхуулиас хамгаалах найдвартай тогтолцоо бий болгоно.

2.7. Шударга ёсоор хуулийн дагуу шийдвэрлэгдээгүй гэмт хэргийн чанартай асуудлуудыг нэгэн мөр болгож, хохирсон иргэдийн гомдлыг барагдуулахад шуух засаглалын анхаарлыг төвлөрүүлнэ. Нийгэмд зан суртахууны эрүүл үндсийг бэхжүүлэх нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэн чухал үндэс гэж үзнэ.

2.8. Улс төрийн харгислагд хэлмэгдэгсдийн нэр төрийг сэргээж, хохирлыг шударгаар нөхөх асудлыг төрийн үүрэг гэж үзэж хэрэгжүүлнэ.

2.9. Мал сүрэг төрийн хамгаалалтад байх тухай үндсэн хуулийн заалт хэрэгжих нийгэм эдийн засаг, эрх зүйн баталгаар буй болгох бодлого баримтална.

2.10. Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлан нийгэмд учруулж буй хор аюул бүхий гэмт халдлагаас хүний амь бие, эрүүл мэнд, өмч хөрөнгийг тууштай хамгаалахад мэрэгжийн байгууллагуудын үүрэг харуулцыг өндөржүүлнэ.

2.11. Шуух, цагдаагийн болон мөрдөн байцаах байгууллагын материал, техник хэрэгслэлийн хангамжийг өнөөгийн шаардлагад нийцүүлэн холбоо мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамруулна.

II. Хүн ардын аж амьдрал, өмч, аж ахуй

3. Амьдралын баталгаа :

Хүн ардынхаа амьдралын баталгааг дээшлүүлэх нь төрөөс нийгмийн өмнө хүлээх одоогийн гол үүрэг гэж үзнэ.

Энэ үндсэн дээр:

3.1. Асрамж дэмжлэггүй өндөр настан, өнчин ядуу хүүхдийг төрийн хамгаалалтанд бүрэн авч тэтгэх баталгаа болгож, үндэсний нийт бүтээгдэхүүний 1%-тай тэнцэх буюу 3 тэрбум төрөлөөс доошгүй хэмжээний хөрөнгөтэй Төрийн сан байгуулж санхүүгийн шууд дэмжлэг үзүүлнэ.

3.2. Цалин, тэтгэвэр, оюутны тэтгэлэгийн доод хэмжээг амьжиргааны өртгийн доод хэмжээнээс багатуульээр тогтоож үнийн өсөлтийн 1% тутамд 0,8%-иас доошгүйгээр улирал тутам нэмэгдүүлнэ. Тэтгэврийг оны ялгаатай тогтоосон одоогийн гажуудлыг шууд арилгаж, дээд түвшинд нь жингдүүлнэ. Тэтгэврийн бодит хэмжээг 2 дахин нэмэгдүүлж, индексжүүлнэ.

3.3. Хөдөлмөрчин хүний эрх ашгийг хамгаалж, өндөр мэргэжилтэй ажилчид, инженер технологийн ажилтныг тогтвортой ажиллуулах хуулийн баталгааг боловсронгуй болгож, Үйлдвэрчний байгууллагын нөлөөг дээшлүүлнэ.

3.4. Холын бүс нутагт ажиллагсдын цалинг төвийн бүсийнхээс 30% хүртэл нэмэгдэлтэй тогтооно.

3.5. Залуучуудыг гэр бүл болж бие даасан амьдралын гараагаа эхлэхэд нь төрөөс орон сууц барих, орон сууц худалдаж авах, бизнес эрхлэх, сурч боловсроход нь удаан хутацааны хөнгөлөлттэй зээл олгоно.

3.6. Залуучуудыг гадаад хэл сурах, компьютерийн

боловсрол олж, олон улсын мэдээллийн сүлжээнд орж харилцах чадвартай болгох сургалтыг төрөөс санхүүжүүлж зохион байгуулна.

3.7. Хувийн төлбөрөөр суралцаж буй оюутнуудад төрөөс хөнгөлөлттэй зээл олгоно. Оюутны хөнгөлөлтийн үндэсний тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн баталгаа буй болгоно. Оюутан залуучуудыг өндөр хөгжилтэй оронд төрөөс санхүүжүүлэн сургах бодлогыг цэгцрүүлж, суралцах оюутны тоог 2-оос доошгүй нэмэгдүүлнэ.

3.8. Төрийн төсвөөс цалинждар хүмүүсийн цалинг 2 дахингаас доошгүй нэмж, амьдралыг баталгаажуулна.

3.9. Монгол Улсын хөдөлмөрийн чадвартай иргэн бүр хөдөлмөрлөж амь зуулгаа хариуцах үүргийг Үндсэн хуулинд оруулж, ажилгүйдлийг хөдөлмөрийн нөөцийн 10% хүртэл бууруулна.

Төв суурин газар амьдарч буй амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай ажилгүйдлүүдэд төрөөс шууд ажлын байр олгож, мэргэжил дараага олоход тусална.

3.10. Архидан согтуурахын эсрэг төрийн цогцолбор бодлого явуулна.

3.11. Олон хүүхэдтэй эхчүүдийн тэтгэврийг нэмэх, тэднийг албадан шахаж ажлын байргүй болгосон гажуудлыг арилгах бодлого явуулна. Эрх толгойлдог нялх балчир хүүхэдтэй эхчүүдэд төрөөс дэмжлэг үзүүлнэ. Эмэгтэйчүүдийн нийгмийн гол асуудлыг шийдэхэд ард түмний санал асуулга явуулж, шударга, ардчилсан ёс зарчмыг баримтална.

3.12. Орон сууцны хувьчлал явуулж, хямд өртөлтэй, тохилго хувийн орон сууц барих төслийг төрөөс ивээн тэтгэж хэрэгжүүлнэ.

3.13. Хүн ардын амьдралын баталгааг дээшлүүлэх дээрх зорилтуудыг шийдвэрлэх гол эх үүсвэрийг одоогийн улсын төсвөөс алдагдал нөхөх, хувийн компаниудад зээл олгох хэлбэрээр зарцуулж буй 40 тэрбум төгрөгийн үрэгдлийг арилгах замаар бий болгоно.

4. Өмч, аж ахуйг тэтгэж сэргээх баталгаа:

Төрийн татвар, зээл, өмч хувьчлал, норматив зохицуулалтын

бодлогыг эрс өөрчилж, өмч, аж ахуйг тэтгэж сэргээх чиглэлтэй болгоно.
Үүнд:

4.1. Аж ахуйн ашиг орлогын татварыг бүхэлд нь 30% бууруулж, бага, дунд үйлдвэрүүдийн бүх татвар үйл ажиллагааны эхний 3 жилд цэвэр орлогын 10-20%-иас хэтрэхгүй байхаар тогтооно.

4.2. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн татварыг хил залгаа хөрш орнуудынхаас давуутай нөхцөл олгохуйцаар шинэчлэн тогтоож 50%-иас доошгүй бууруулна.

4.3. Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг татвараас чөлөөлнө. Мал эмнэлэг, үржил, ургамлын селекцииг албaдыг төрөөс хүчтэй дэмжинэ.

4.4. Орчин үеийн шинэ дэвшилтэт техник, технологийн импортыг гаалийн татвараас чөлөөлөх хүртэл хөнгөлөлт үзүүлнэ.

4.5. 1996 оны 4-р сарын 1-нээс өмнө төлөгдөөгүй татварын бүх өрийг цайруулан хаяж, гадаадын банкуудад хадгалж байсан мөнгийг өөрийн улсад шилжүүлэн оруулахад 1996 онд багтан бүх татвараас чөлөөлнө.

4.6. Эрхийн бичгээр хувьцаа авсан иргэдийн хувьцааг тухайн аж ахуйн хөрөнгийн үнэлгээний өсөлтөөр индексжүүлж өмчийн эрхийг нь сэргээнэ.

4.7. Малчдын хувийн аж ахуйг бие даасан аж ахуйн нэгжийн эрхийн баталгаатай болгож, банкинд данс нээх, зээл авах, бэлэн бус мөнгөөр төлбөр тооцоо хийх, бусад аж ахуйтай гэрээ хэлцэл хийх, дотоод гадаадын зах зээлд бүтээгдэхүүнээ өөрөө худалдаалах эрхийг бүрэн эдлүүлнэ.

4.8. Малчдын аж ахуйгаас мал мах, түүхий эд худалдан авах үнийн доод хязгаарыг жил бүр төрөөс тогтоож баталгаажуулна. Засгийн газар, төрийн байгууллагын үйл ажиллагаанаас шууд шалтгаалан хэлмэгдэж хохирсон буюу дамлуурсан хувийн аж ахуйн нэгжүүдэд нөхвөр олгох, сэргээн тэтгэх төрийн сан байгуулна.

4.9. Зээл, зээлийн хүүгийн бодлогын мөнгө хууль чиглэлийг эрс өөрчлөн үндэсний аж ахуйг тэтгэх бодлого явуулж:
a) Хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээлийн сан байгуулж,

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкттай болно. Хөрөнгө оруулалтын зээлийн жилийн хүүг 10%-иас хэтрүүлэхгүй тогтооно.

б) Хөдөө аж ахуй, түүний дотроос газар тариаланг дэмжих сан байгуулж, ХАА-н банкиг сэргээн ажиллуулна. Газар тариалангийн техникийн шинэчлэлийг дэмжинэ.

Уст цэг, усгалтын системүүдийг төрийн хамгаалалтад авч, эзэмшил, өмчлөлийн асуудлыг тухайн орон нутгийн нөхцөл, онцлогийг харгалзан шийдвэрлэнэ.

в) Хөрөнгө оруулалтын зээлийн 1/4-ээс доошгүй хувийг алсын бүс нутгийг хөгжүүлэхэд зориулна.

г) Зээлийн хүүгийн бодлогыг эдийн засгийн хөгжлийг дэмжих чиг баримжатай болгоно.

4.10. Хувийн өмчийн болон хувийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд өөрийнхөө үл хөдлөх хөрөнгийг тухайн цаг үеийн валютын ханш, үнэлгээг харгалзан үндэслэлтэйгээр дахин үнэлж, сэргээн босголтын шимтгэл байгуулахыг бүрэн зөвшөөрч, шимтгэлийн санг хадгаламжийн хэлбэрээр ашиглуулна.

5. Эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, зах зээлийн шилжилтийг тууштай болгоно.

5.1. Өмч хувьчлалыг гүнзгийрүүлэн, төрийн өмчийн аж ахуйн хөрөнгийн 70%-ийг хувьчилна. Өмч хувьчлалын гажуудал, завхралыг зохих хуулийн дагуу шийдвэрлэнэ.

5.2. Банкуудын өрсөлдөөний нөхцлийг сайжруулж, хөгжлийн болон хувийн өмчийн банк байгуулахыг дэмжин, банкны зээлийн даатгалын сан байгуулна.

5.3. Хөрөнгийн болон валютын биржүүдийг бүх талаар дэмжин төлөвшүүлж, хөдөө аж ахуйн биржүүдийг сэргээнэ.

5.4. Малчдын хувийн аж ахуйг зах зээлтэй холбох дэд бүтцийг бий болгож, хөдөө аж ахуйн биржийн салбар, үнэ хялцуулах худалдааг сүмдэд зохион байгуулна.

5.5. Дархан, Эрдэнэт, Чойбалсан, Улиастай хот, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Дорноговийн Замбын-Уд боомтуудыг эдийн засгийн чөлөөт бүс болгон гадаадын хөрөнгө оруулалт, худалдаа санхүүгийн үйл ажиллагааны төвүүдийг байгуулна.

5.6. Эрчим хүчний үнийг чөлөөт тогтолцоонд шилжүүлж,

үйлдвэрлэлд технологийн шинэчлэлт хийнэ. Цахилгаан эрчим хүчээр улс орны хэрэгцээг бүрэн хангах хүчин чадал бий болгох үндсийг тавина.

5.7. Газар тариалангийн үйлдвэрлэлийн техник, технологийн шинэчлэлийг төрөөс дэмжиж үйлдвэрлэлийг бүрэн сэргээнэ.

5.8. Зэсийн баяжмал, газрын тосыг дотоодод бүрэн боловсруулах бодлого баримтална.

5.9. Хар төмөрлөгийн түүхий эдийн боловсруулалтыг технологийн дээд түвшинд хүргэж өрнө, дорнын төмөр замын шугамын үндсийг тавина.

5.10. Жижиг, дунд үйлдвэрийг амьдрах чадварын баталгаатай болтол төрөөс дэмжих тогтолцоо бий болгоно.

5.11. Газар өмчлөл, эзэмшлийн асуудлыг Үндсэн хуулийн заалтын дагуу шийдвэрлэнэ.

5.12. Гадаадын зээл, тусламжийг хөгжилд зориулах бодлого баримталж, өндөр үр ашигтай үйлдвэр байгуулах, бүх салбарт технологийн шинэчлэлт хийх, дэд бүтцийг хөгжүүлэхэд ашиглана. Гадаадаас авсан зээл тусламжийн зориулалт, ашиглалтыг олон түмэнд ил тод, бүрэн мэдээлдэг болгоно.

5.13. Төрийн мөнгөний бодлогыг оновчтой явуулж, цаасан мөнгө гүйлгээнд гаргаж төсөв санхүүжүүлэх, хувийн цөөн аж ахуйг дэмжих болон бусад хэлбэрээр илэрч буй гажуудлыг арилгаж, валютын арилжааг чөлөөтэй болгож, ханшийн хязгаар тогтоон тогтворжуулах арга хэмжээ авна.

5.14. Төрийн эдийн засгийн бодлогыг бүсчилсэн хандлагатай болгож, бүс нутгийн цогцолборын эдийн засгийн бие даасан байдлыг дээшлүүлнэ.

III. Хүн амын эрүүл мэнд, үндэсний удмын сангийн аюулгүй байдал

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, үндэсний удмын сангийн аюулгүй байдлыг хангах асуудлыг хэгийн бодлогоотой шийдвэрлэхэд төрийн бодлого чиглүүлэх шаардлага нэн хурц болж байна. Энэ талаар :

6. Эрүүл мэндийг хамгаалах тогтолцоог өөрийнхөө орны

орчин нөхцөл, ахуй амьдралын онцлолт зохицуулсан өөрчлөх үйл явцыг түргэтгэж, шинэ бүтэц бий болгоно.

6.1. Хувь хүн өөрийн эрүүл мэндийг хөдөлгөөнөөр болон эрүүл хэрэглээгээр хамгаалж, эрүүл аж төрөх соёл эзэмших явдлыг бүх нийтийн үүрэг гэж үздэг харилцарын тогтолцоо бий болгоно.

6.2. 65-аас дээш насны өгтөс, 16 хүртэлх насны хүүхэд, хөдөлмөрийн чадваргүй хүмүүсийг хэвтэж эмчлүүлэх хугацаа, тоог харгалзахгүй үнэ төлбөргүй эмчилнэ.

6.3. Хувийн эмнэлгээр эмчлүүлэгчдийг даатгалын тогтолцоонд бүрэн хамруулна.

6.4. Монгол Улсын хэмжээнд нутаг дэвсгэрийн харьяаллыг харгалзахгүйгээр эмчлэх ба эмчлүүлэх зарчмыг баримтална.

6.5. Хөхүүл эмэгтэйчүүдэд хүүхдийг нь 2 нас хүртэл төрөөс тэтгэлэг олгож, эргэж ажилд орох эрхээр хангах.

6.6. Хүн ардын хэрэглээний гол зүйлүүдэд эрүүл мэнд, эрүүл ахуйн шаардлагын үүднээс мэргэжлийн нарийн хяналтын журам тогтоож, аливаа хорт зүйлээс сэргийлэх чанд бодлого явуулна. Хүнсний ногоо, өндөг, төрөл бүрийн мах, сүүг зах дээр худалдах эрхийг зөвхөн үйлдвэрлэл эрхлэх эрхийн баталгаа бүхий хүмүүст олгож, эмнэлэг-арин цэврийн хяналтыг хүчтэй болгоно.

6.7. Удамшлын өвчин, гажуудлын эсрэг тэмцэх төрийн хөтөлбөр хэрэгжүүлнэ.

IV. Монгол орны оюуны хүрээ, соёлын хөгжлийн асуудлыг тэргүүн зэрэгт үзсэн төрийн бодлогыг бодитой хэрэгжүүлэх тухай

7. Ерөнхий боловсролын тогтолцоог шинэ зарчим, шинэ зохион байгуулалтаар сэргээж хөгжүүлнэ.

7.1. Ерөнхий боловсролын тогтолцоо нь хүүхдэд бага наснаас нь үндэсний түүх, зан суртахууны өв, мэдлэг ухааны дэвшилтэт сангаас эзэмшүүлэн, хүмүүжил боловсрол олгох цогц зорилттой байна.

7.2. Ерөнхий боловсролын сургалтыг нийгмийн орчин үеийн шаардлагад нийцсэн мэдлэг өгч, мэдлэгийг амьдралд хэрэглэх чадвар олгох хөс зорилготой байлгана. Бүрэн бус дунд сургууль төгссөн хүүхдүүдэд мэргэжлийн баримжаа олгох тогтолцоо бий болгоно.

7.3. Ерөнхий боловсролын сургуулийн 9-10-р ангиудыг тодорхой мэргэжилд чиглэсэн төрөлжсөн сургалтын чиг баримжаатай болгоно.

7.4. Хөдөө нутагт бага ангийн суралгчдын алсын зайн сургалтыг улсамжилалт болон шавь сургалттай хослуулах тогтолцоог бий болгоно.

7.5. Ерөнхий боловсролын сургуулиудын сурах бичиг, лаборатори, туршилтын баазыг орчин үеийн хөгжингүй орнуудын түвшинд хүргэнэ.

7.6. Ерөнхий боловсролын санхүүжилтийг УНБ-ний 5%-иар тогтоож бодит хэмжээг 1995 оныхоос 30% нэмэгдүүлэхийн дээр техник тоноглол, үзүүлэн, сурах бичгийн зардалд эхний 3 жилд 30 сая ам.доллар нэмж зарцуулна.

8. Их, дээд сургуулиудын үйл ажиллагааг сургалт-эрдэм шинжилгээний чиглэлтэй болгох зорилтыг бүрэн шийдвэрлэж, сургалтын болон сорилт туршилт, эрдэм шинжилгээний лаборатори, зохион бүтээх товчоод, туршилт үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлнэ. Хувийн дээд сургуулиудын хичээлийн байр-техник тоноглолын асуудлыг шийдэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ. Их, дээд сургуулийн багш нарын мэргэжил дээшлүүлэх, эрдэм шинжилгээний ажил хийх нөхцөл боломжийг эрс сайжруулж, номын сангуудыг орчин үеийн дэлхий нийтийн жишигт хүртэл хөгжүүлнэ.

Боловсролын хүрээнд менежментийн хувьчлалыг идэвхтэй явуулна. Монголын бизнесийн менежмент, сургалтын тогтолцоо бий болгоно.

9. Шинжлэх ухааны хөгжил, эрдэм шинжилгээ, зохион бүтээх үйл ажиллагааг төрөөс дэмжих тогтолцоог хүчтэй болгож, энэ зорилгоор улсын төсвөөс зарцуулах зардлыг УНБ-ний 3%-д хүргэнэ. Эрдэм шинжилгээний онцгой ач холбогдолтой чиглэлүүдээр төрийн төсөл хэрэгжүүлнэ. Шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний салбарын зохион байгуулалтыг нийгмийн амьдралын шинэ нөхцөлд нийцүүлэн өөрчилж, хувийн секторт эрдэмтдийн төрөлжсөн судалгаа шинжилгээний

төвүүд байгуулахыг бүх төлсөр дэмжинэ. Эрдэм шинжилгээ, зохион бүтээлтийн үр дүнг эдийн засагт хэрэглэхэд төрөөс дэмжлэг үзүүлж, оюуны бүтээлийн зах зээлийн дэд бүтцийг бий болгоно.

10. Соёлын хүрээг сэргээн хөгжүүлэх төрийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ. Соёлын хүрээг төрөөс тэтгэх санхүүжилтийг ҮНБ-ний 1%-иас багагүйгээр тогтооно. Сумдын төвийн соёлын төвүүдийг шинэ тогтолцооны нөхцөлд нийцүүлэн соёл урлагийг гүтгээх үндэсний уламжлалт арга хэрэгслийг сэргээх замаар урлаг соёлын үйлчилгээг ард түмэнд ойртуулна.

11. Үндэсний телевизийн нэвтрүүлэгт соёл, шинжлэх ухаан, боловсролын бие даасан суваг нээж төрөөс санхүүжүүлж тэтгэнэ.

12. Соёл, шинжлэх ухаан, боловсролын салбарыг төрөөс тэтгэхэд зориулан зарцуулах хөрөнгө нь Улсын төвийн орлогын 30%-иас доошгүй байхаар хуульчлан тогтоох бөгөөд эдгээр салбарт онцгой ач холбогдолтой бүтээл гаргасан хүмүүсийг жил бүр шалгаруулан урамшуулж амьдралыг нь баталгаажуулах "Алтан соёмбо" шагналыг бий болгоно. Шагналын хэмжээ хүн бүрд 20000 ам.доллараас багагүй байх болно.

13. Монгол төр хүн ардынхаа сэтгэлийг ариусгаж, хүмүүнлэг, энэрэнгүй зан суртахууныг төлөвшүүлэхэд уламжлалт шашнаа түшиглэж, түүний шинэчлэлтийг дэмжих нь нийт ард түмний эрх ашигт нийцнэ гэж үзэнэ.

14. Соёл, боловсрол, эрүүлийг хамгаалах, шинжлэх ухааны хүрээг дэмжсэн үйлдвэр аж ахуйн байгууллага, хүмүүсийг татвараас чөлөөлөх хөнгөлөх бодлого баримтална.

У. Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгааг бэхжүүлэх асуудал

Үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын баталгааг бэхжүүлэх нь орчин цагийн дэлхий нийтийн болон бүс нутгийн нөхцөлтэй уялдуулан гийндрвэрлэх төрийн бодлогын нэн чухал тулгамдсан асуудал гэж үзэнэ.

Энэ зорилгоор:

13. Улс орны аюулгүй байдлын баталгааг бүрдүүлэх

асуудлыг шийдвэрлэхдээ аль болох богино хугацаанд хоцрогдлыг гэтэлж хурдан хөгжлийн замд орохыг эрхэмлэхийн зэрэгцээ бүс нутгийн идэвхитэй хамтын ажиллагаа, аюулгүй байдлын харилцан хамаралтай тогтолцоо үүсгэх бодлого баримтална.

14. Айл, саахалтын хөрш орнуудтай найрсаг харилцаа, хамтын ажиллагааг эрхлэн хөгжүүлж, Азийн төв бүсийн тогтвортой, аюулгүй байдлын тогтолцоо бий болгоход чиглэсэн алхамууд хийнэ.

15. Өндөр хөгжилтэй, хүчирхэг улс гүрнүүдийн байнгын сонирхол бий болгож, геополитикийн олон туйлт таагтай орчин бүрдүүлэхийг эрмэлзэнэ.

16. Улс төр, эдийн засаг, оюуны ертөнц болон экологийн аюулгүй байдлыг хамгаалах төрийн бодлогын хөтөлбөр гаргаж хэрэгжүүлнэ.

17. Монгол Улсын зэвсэгт хүчний бүтэц зохион байгуулалтыг өөрчилж мэргэжлийн цомхон армитай байхын зэрэгцээ бүх нийгээр цэргийн бэлтгэлтэй байж, улс орноо батлан хамгаалах номлолыг баримтална.

18. Монгол Улсын нутаг дэвсгэр дэлхийн шим мандлын олон Улсын хамгаалалттай тусгай бүс байх чиг бодлогыг үргэлжлүүлнэ. Хот суурин газруудын хог хаягдлаар хөрс, ус бохирдуулах явдлыг зогсоох нь экологийн хүрээнд эн тэргүүнд шийдэх асуудал байх болно. Уул уурхайн үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд экологийн аюулгүй байдлын өндөр шаардлага бүхий стандарт тогтоон мөрдүүлнэ.

19. Гадаад улс орнууд, тэдгээрийн аж ахуйн нэгж, хувь хүмүүстэй байгуулсан Монгол Улсын нийтлэг эрх ашгийг хөндсөн гэрээ, хэлэлцээрүүдийг Үндэсний аюулгүй байдлын шаардлагын үүднээс үнэлж шийдвэрлэнэ.

20. Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөлийн үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалтыг шинэчилж, улс нийгмийн аюулгүй байдлыг хамгаалах төрийн бодлогын төв болгоно.

21. Орос улстай харилцахад ЗХУ-аас өвлөж үлдсэн Монголын өрийн асуудлыг ОХУ-ын Засгийн газрын 1995 оны 10-р сарын саналыг үндэс болгон хоёр орны нийтлэг эрх ашиг, цаашдын хамтын ажиллагааны хөгжилд таатай нөлөөлөх

эсрчмын үүднээс шийдвэрлэнэ.

22. АНУ, Герман, Япон зэрэг өндөр хөгжилтэй, нөлөө бүхий орнуудтай тогтоосон хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлж цаашид хөрөнгө таварын тэгш хэмтэй тогтвортой урсгал үүсгэхийг эрмэлзэнэ. Азийн төв бүс нутгийн хөгжил цэцэглэл, тогтвортой байдал тэдгээр орны оролцоотой шийдвэрлэгдэнэ гэж үзэж сайн түншийн найрсаг харилцааг эрхэмлэнэ.

23. Хөрш зэргэлдээ Орос, Хятад, Казахстан улсуудтай хамтын ажиллагаа, сайн хөршийн найрсаг харилцааг харилцан хүндэтгэлтэйгээр эрхлэн хөгжүүлж, удаан хугацаны тогтвортой чиглэл бүхий эдийн засгийн хамтын ажиллагааг эрхэмлэн бүс нутгийн аюулгүй байдлын олон талын оролцоотой баталгаа бүрдүүлэхэд эрх тэлшээр хүчин чармайлт тавихыг чухалчилна.

24. Монгол улс Төвийг сахисан, нээлттэй эдийн засагтай орон байж, бүс нутагтаа олон улсын худалдаа, санхүүгийн нэгэн гол төв болохын үндсийг тавина.

25. Цагаачлагчид Монгол оронд орж ирэх журмыг зохицуулсан хууль тогтоомжийг шинэчлэн, гадардаас ажиллах хүч авах явдлыг нарийн чанд дэлгтэй болгож, ажиллах хүч элсүүлэх зарлал нийтэд гаргаж, элсэлт явуулсаны дараа дутагдсан хүн хүчийг нөхөх зорилгоор гадардаас хүч авахыг зөвшөөрнө.

Хилийн чанадад амьдарч буй монголчуудад чөлөөтэй ирж амьдрах, монгол улсын иргэний адил эрх эдэлж, үүрэг хүлээх эрх зүйн болгоцоо бүрдүүлнэ.

VI. Хөгжил дэвшлийн зам

Монгол орон нийгэм, улс төр, эдийн засаг, оюуны хүрээний хямралыг гэтэлж, цаашид хөгжиж цэцэглэх замд орох бодит боломжтой гэж үзэж дараах үндсэн зорилтыг шийдвэрлэнэ.

26. Улс нийгмээ ардчилсан ёсоор зохион байгуулах чадвартай, ард түмнийхээ итгэл хүлээсэн Ерөнхийлөгчийн засаглалтай шударга төр бий болно.

27. Улс орны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг үндэсний хөтөлбөр болгон тодруулан боловсруулж, монгол хүний амьдралын чанар нь эрдэм оюуныг дээдлэн, эрүүл энх, амгалан тайван, элбэг хангалуун аж төрөхийн солбицол

дээр тасралтгүй сайжрах үндсийг тавина.

28. Монгол улсын цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээ байгуулж, эх орны эрдэс, түлш, ус, салхины эрчимд түшиглэн ирээдүйн хөгжлийн хэрэгцээг хангахуйц хүчин чаддал бий болгох олон улсын хамтын ажиллагааны төсөл боловсруулан хэрэгжүүлэх эхлэл тавина.

29. Эх орны эрдэс, мал аж ахуй, газар тариалангийн түүхий эдэд түшиглэсэн аж үйлдвэрийн салбаруудыг орчин үеийн техник, технологиуд тулгуурлан сэргээж, боловсруулалтыг дэвшүүлж, экспортны үйлдвэрлэлийг бүх бололцоогоор дэмжиж, хөгжүүлнэ. Газрын тос, зэсийн нөөцөө дотооддоо боловсруулах бодлого явуулна.

30. Монгол оронд олон улсын аялал жуулчлалын цогцолбор байгуулах төсөл боловсруулж хэрэгжүүлж эхэлнэ.

31. Монгол улсад эдийн засгийн чөлөөт бүсүүдийг зохион байгуулж, гадардын хөрөнгө хүчний сонирхлыг татах бодлого явуулна. Олон улсын санхүү, худалдааны бүс нутгийн төвийн дэд бүтцийг бүрдүүлж хөгжүүлнэ.

32. Үндэсний боловсрол, соёл, шинжлэх ухааны тогтолцоог орчин үеийн хамгийн шилдэг арга туршлагад тулгуурлан хөгжүүлнэ.